

Уриалга

ГЭРЭЭТ БА ХУВИЙН ХАМГААЛАЛТЫН БАЙГУУЛЛАГА, АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ХАМГААЛАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР СУРГАЛТ СУДАЛГАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭ, ХУДАЛДАА, ҮЙЛДВЭРЛЭЛ, БЭЛТГЭН НИЙЛҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЭЛДЭГ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ДАРГА ЗАХИРАЛ, ИРГЭН ТАНАА

Таны энэ өдрийн амгаланг айлтгая.

Монгол улсад аюулгүй байдал, харуул хамгаалалтын салбарын хууль эрх зүйн орчныг сайжруулах, ажил үйлчилгээний чанар, стандартыг олон улсын жишигт хүргэх, нийцүүлэх, энэ салбарт үйл ажиллагаа явуулж буй байгууллагуудын бизнесийн болон хуулиар олгогдсон эрх ашгийг хамгаалах, аюулгүй байдлын шинэ техник технологи, инновацийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх, ажилтнуудын сургалт бэлтгэлийг нэгдсэн тогтолцоонд оруулах, төрийн байгууллагуудтай хамтран ажиллах, ажиллагсдын эрх зүйн болон нийгмийн байдлыг дээшлүүлэх чиглэлээр аюулгүй байдал хамгаалалтын байгууллагуудын үйл ажиллагааны нэгдлийг хангахын тулд аюулгүй байдал, хамгаалалтын холбоод нэгдэж, 2022 оны 12-р сарын 15-нд Их хурал хуралдуулж, “Монголын Аюулгүй Байдал, Хамгаалалтын Нэгдсэн Холбоо” байгуулагдсан.

Тус Их хуралд аюулгүй байдал, хамгаалалтын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 200 гаруй байгууллагын төлөөлөл оролцож, Холбооны дүрэм хэлэлцэн баталж, Холбооны Удирдах зөвлөлийг 19, Хяналтын зөвлөлийг 5 хүний бүрэлдхүүнтэй сонгож, Холбооны ерөнхийлөгчөөр миний бие сонгогдсон билээ. Төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааг дэмжих төр засгийн бодлогод нийцүүлэн салбарын хөгжилд илүү их санаачлага гаргах, түүнийгээ төр захиргааны байгууллагаар дэмжүүлэх, аюулгүй байдал, хамгаалалтын ажил үйлчилгээний үндэсний стандартыг хэрэгжүүлэх, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн стандартуудыг нэвтрүүлж, нутагшуулах, энэ салбарт үйл ажиллагаа эрхлэгчдийн бизнесийг үр өгөөжтэй болгоход мэдлэг, туршлагаа дайчлан багаараа нэгдэн ажиллах болно.

Ижил төстэй зорилго чиглэл бүхий Төрийн бус байгууллагууд нэгдэн нийлж, Нэгдсэн холбоо байгуулагдсан нь төр захиргааны болон хууль хяналтын байгууллагуудтай нэг цонхоор нэгдсэн бодлогоор харилцаж, хуулийн хүрээнд гадаад дотоодын байгууллагуудтай хамтран ажиллах, гишүүд нь ашиг сонирхлоо хамгаалах, мэдлэг мэдээллээ хуваалцах, хамтдаа урагшилж хөгжих боломж юм. Мөн зөвхөн гэрээт харуул хамгаалалтын байгууллагууд бус энэ салбарын хөгжилд үнэт хувь нэмэр оруулах аюулгүй байдлын эрдэмтэн мэргэд, мэргэжилтнүүд, үндэсний аюулгүй байдлыг хангах чиглэлийн байгууллагуудад ажиллаж байсан мэдлэг туршлагатай ажилтнуудын хоёрдогч ажлын талбар бол энэ салбар. Нөгөө талаар дэлхийд аюулгүй байдлын шинэ техник технологи маш өндөр хурдацтай хөгжиж байгаа ба түүнээс хоцрохгүй, хамтдаа урагшлахыг эрмэлзэх ёстой гэж ойлгодог.

Иймд гэрээт ба хувийн хамгаалалтын байгууллагуудын эрхэм захирал, удирдлагууд, аюулгүй байдлын эрдэмтэн судлаачид, энэ салбарт бараа бүтээгдхүүн нийлүүлэгч хуулийн этгээд, хувь иргэн Та бүхнийг тус холбооны үйл ажиллагааг дэмжин, салбарын хөгжилд оюун ухаан, мэдлэг туршлага, санаачлага зүтгэлээрээ хүч нэмж, гишүүнчлэлээр нэгдэн, үр бүтээлтэй, харилцан ашигтай хамтран ажиллахыг уриалж байна.

Олны хүч оломгүй далай гэдэг билээ. Нэгдэж чадвал хөгжлийн түлхүүр бидэнд буй. Энэ салбарын хөгжлийн төлөө мэдэх чадах бүхнээрээ хамтран ажиллахыг эрхэм хүндэт найз нөхөд та бүхнээсээ хичээнгүйлэн хүсье.

ХҮНДЭТГЭСЭН,

ЕРӨНХИЙЛӨГЧ

С.ЭНХСАЙХАН